**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/183/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2022 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Үүрийнтуяа<br>Утас: 90832211 Цахим хаяг:uuriintuya.b@ audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....12

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....13

3. Аудитын тайлан....15

3.1 Ерөнхий зүйл....15

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....15

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....16

3.4 Материаллаг байдал ....16

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....16

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....18

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....19

3.8 Аудитын гол асуудал ....20

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....20

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....20

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....20

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....20

4. Аудитын илрүүлэлт ....21

4.1 Залруулсан алдаа.... 21

4.2 Төлбөрийн акт.... 21

Байхгүй .... 21

4.3 Албан шаардлага .... 21

4.4 Зөвлөмж .... 21

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....21

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2022.02.25 № 153
танай ______ -ны № ______ -т

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА Х.МАНЧУК ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **451,129,440.87** | **2,698,228,711.33** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 0.01 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| 31110 | Төгрөг | - | - |
| 31140 | Касс арилжааны банк | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 0.01 |
| **3121** | **Төгрөг** | - | 0.01 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 0.01 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | - | - |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | - |
| **33** | **АВЛАГА** | 85,996,400.00 | 2,256,199,057.10 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 2,256,199,057.10 |
| **335** | **Бусад авлага** | 85,996,400.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 85,996,400.00 | |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 365,133,040.87 | 442,029,654.22 |
| **351** | **Түүхий эд материал** | 184,510,085.64 | 177,599,540.99 |
| 35130 | Эм боох материал | 184,510,085.64 | 177,599,540.99 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 20,000.00 | 20,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 180,602,955.23 | 264,410,113.23 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,353,882.90 | 14,325,700.90 |
| 35420 | Аж ахуйн материал | 51,674,796.85 | 79,503,736.85 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,909,231.69 | 1,909,231.69 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | |
| 35450 | Барилгын засварын материал | 9,604,049.37 | 15,948,699.37 |
| 35460 | Хүнсний материал | - | |
| 35470 | Бусад хангамжийн материал | 108,060,994.42 | 152,722,744.42 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **15,609,406,092.15** | **19,533,659,607.73** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 15,609,406,092.15 | 19,533,659,607.73 |
| **392** | **Биет хөрөнгө** | 15,172,606,092.15 | 19,060,997,485.73 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 13,711,751,939.47 | 14,145,913,789.47 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (514,380,622.80) | (853,261,425.89) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 455,070,888.00 | 516,070,888.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (333,237,394.92) | (331,036,493.16) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 7,256,614,617.14 | 10,153,413,723.97 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (5,651,899,740.22) | (5,480,262,284.28) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 773,886,193.79 | 1,468,434,661.92 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (675,890,974.73) | (697,117,349.48) |

| | | | |
|---|---|---|---|
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 167,953,545.36 | 167,953,545.36 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (18,198,422.40) | (30,047,633.64) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | - | - |
| 39217 | Ном | 936,063.46 | 936,063.46 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 436,800,000.00 | 472,662,122.00 |
| 39301 | Програм хангамж | 1,250,000.00 | 57,512,122.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,250,000.00) | (1,250,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 436,875,500.00 | 416,475,500.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (75,500.00) | (75,500.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **16,060,535,533.02** | **22,231,888,319.06** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **485,209,785.01** | **648,242,439.78** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 485,209,785.01 | 648,242,439.78 |
| **413** | **Өглөг** | 485,209,785.01 | 648,242,439.78 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 17,042,593.70 | 8,770,567.42 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | - |
| **4136** | **Бусад өглөг** | 468,167,191.31 | 639,471,872.36 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 467,890,991.31 | 638,432,672.36 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 276,200.00 | 1,039,200.00 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | | |
| 41364 | НДШ - ийн өглөг /ТӨҮГ/ | | |
| 41365 | Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/ | | |
| 41366 | Дансны өглөг /ТӨҮГ/ | | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **15,575,325,748.01** | **21,583,645,879.28** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 15,575,325,748.01 | 21,583,645,879.28 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,633,020,649.16 | 4,633,020,649.16 |
| 51101 | Өмч: - төрийн | 4,633,020,649.16 | 4,633,020,649.16 |
| 51102 | - хувийн | - | - |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,616,195,977.56 | 8,628,775,032.38 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (1,876,125,792.74) | 2,620,454,901.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 4,492,321,770.30 | 6,008,320,131.27 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 8,326,109,121.29 | 8,321,850,197.74 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **16,060,535,533.02** | **22,231,888,319.06** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **15,271,469,505.42** | **20,295,801,899.07** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **-** | **-** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,577,594,349.92** | **5,924,042,455.07** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 220,058,170.92 | 939,127,034.20 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 220,058,170.92 | 939,127,034.20 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 122,556,936.00 | 153,936,322.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 97,501,234.92 | 785,190,712.20 |
| **122** | **Тусламжийн орлого** | 5,357,536,179.00 | 4,984,915,420.87 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 5,357,536,179.00 | 4,984,915,420.87 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | - | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **9,693,875,155.50** | **14,371,759,444.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 6,422,040,200.00 | 215,000,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 6,422,040,200.00 | |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | - | 215,000,000.00 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | - | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 237,487,620.50 | 945,664,475.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 400,000.00 | 25,635,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 214,567,250.00 | 877,877,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,520,370.50 | 42,152,475.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | - |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | - |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | - | - |
| 133002 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,034,347,335.00 | 13,211,094,969.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 3,034,347,335.00 | 13,211,094,969.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **10,779,147,735.12** | **14,224,594,189.82** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,779,147,735.12** | **14,143,044,189.82** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 10,773,880,389.12 | 13,581,644,189.82 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 6,202,199,059.23 | 6,762,258,617.58 |
| 210101 | Үндсэн цалин | 6,200,767,437.23 | 6,762,258,617.58 |
| 210102 | Нэмэгдэл | 711,081.00 | |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | - |
| 210104 | Урамшуулал | 720,541.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 767,790,855.00 | 893,672,054.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 767,790,855.00 | 893,672,054.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 861,836,378.00 | 759,107,401.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 71,509,866.00 | |
| 210302 | Түлш, халаалт | 574,912,601.00 | 759,107,401.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 215,413,911.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 194,624,399.38 | 304,504,487.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 70,715,149.28 | 110,942,582.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 110,445,206.00 | 175,107,095.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,436,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 3,864,060.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 5,775,024.10 | 14,590,750.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,895,504,730.28 | 2,973,777,794.53 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,642,156,978.88 | 2,963,807,294.53 |
| 210502 | Хоол, хүнс | 220,879,800.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 32,467,951.40 | 9,970,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 31,655,901.49 | 34,485,050.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 926,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 30,729,901.49 | 34,485,050.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 22,247,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 22,247,000.00 | |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,504,400.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 689,400.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 407,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | |
| 210807 | Газрын төлбөр | 1,200,000.00 | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 200,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 794,517,665.74 | 1,853,838,784.31 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,750,000.00 | 812,868,457.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 789,767,665.74 | 1,040,970,327.31 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | - | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,267,346.00 | 561,400,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,847,700.00 | 561,400,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | - |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | - | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,847,700.00 | 561,400,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,419,646.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,419,646.00 | |
| 213304 | Хөрөнгийн | - | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - |
| 213404 | Хөрөнгийн | - | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **81,550,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 81,550,000.00 |
| 220001 | Барилга байгууламж | - | - |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 81,550,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **4,492,321,770.30** | **6,071,207,709.25** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | 4,950,000.00 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | | 4,950,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 145003 | Хөрөнгө оруулалтын олз | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 67,837,577.98 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 67,837,577.98 |
| 225008 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээл | - | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (62,887,577.98) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **4,492,321,770.30** | **6,008,320,131.27** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 4,633,020,649.16 | 8,326,109,121.29 | 2,616,195,977.56 | **15,575,325,748.01** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,633,020,649.16** | **8,326,109,121.29** | **2,616,195,977.56** | **15,575,325,748.01** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | - |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,633,020,649.16** | **8,326,109,121.29** | **2,616,195,977.56** | **15,575,325,748.01** |
| D01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **4,633,020,649.16** | **8,326,109,121.29** | **2,616,195,977.56** | **15,575,325,748.01** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 4,258,923.55 | **4,258,923.55** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,633,020,649.16** | **8,326,109,121.29** | **2,620,454,901.11** | **15,579,584,671.56** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | (4,258,923.55) | | **(4,258,923.55)** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 6,008,320,131.27 | **6,008,320,131.27** |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,633,020,649.16** | **8,321,850,197.74** | **8,628,775,032.38** | **21,583,645,879.28** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **9,816,432,091.50** | **12,269,496,708.90** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | - | - |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **122,556,936.00** | **153,936,322.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 122,556,936.00 | 153,936,322.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 122,556,936.00 | 153,936,322.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 122,556,936.00 | 153,936,322.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **9,693,875,155.50** | **12,115,560,386.90** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 6,422,040,200.00 | 215,000,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 6,422,040,200.00 | |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | | 215,000,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 237,487,620.50 | 945,664,475.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 400,000.00 | 25,635,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 214,567,250.00 | 877,877,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,520,370.50 | 42,152,475.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,034,347,335.00 | 10,954,895,911.90 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 3,034,347,335.00 | 10,954,895,911.90 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **9,792,754,091.50** | **12,221,350,708.89** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **9,792,754,091.50** | **12,221,350,708.89** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **9,787,486,745.50** | **11,659,950,708.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 6,168,351,303.00 | 6,692,769,116.00 |
| 210101 | Үндсэн цалин | 3,813,434,200.00 | 3,530,443,216.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,684,026,700.00 | 2,344,822,500.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 267,498,000.00 | 277,893,000.00 |
| 210104 | Урамшуулал | 403,392,403.00 | 539,610,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 785,827,021.00 | 945,662,443.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 557,194,621.00 | 697,668,643.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 57,158,100.00 | 61,998,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 45,726,500.00 | 49,598,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 11,431,600.00 | 12,399,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 114,316,200.00 | 123,996,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 783,224,594.00 | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 71,509,866.00 | |
| 210302 | Түлш, халаалт | 498,700,728.00 | |
| 210303 | Цэвэр, бохир ус | 213,014,000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 167,239,470.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 8,160,700.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 110,573,300.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,436,000.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 34,828,220.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,241,250.00 | |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 1,695,883,128.50 | 20,035,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,448,514,073.50 | 10,535,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 220,879,800.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 26,489,255.00 | 9,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 138,129,629.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 89,648,000.00 | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,000,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 45,481,629.00 | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 22,247,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 22,247,000.00 | |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 21,734,600.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 689,400.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 407,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | |
| 210807 | Газрын төлбөр | 182,000.00 | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 200,000.00 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 19,248,200.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,850,000.00 | 4,001,484,149.89 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,850,000.00 | 4,001,484,149.89 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,267,346.00** | **561,400,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,847,700.00 | 561,400,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,847,700.00 | 561,400,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,419,646.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,419,646.00 | |
| 213304 | Хөрөнгийн | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **23,678,000.00** | **48,146,000.01** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **-** | **-** |
| 140001 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| 140002 | Улсын төсвөөс олгосон зээл | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **23,678,000.00** | **48,146,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **23,678,000.00** | **48,146,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 23,678,000.00 | 48,146,000.00 |
| 220001 | Барилга байгууламж | | |
| 221001 | Их засвар | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 23,678,000.00 | 48,146,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(23,678,000.00)** | **(48,146,000.00)** |
| 14 | **Бусад эх үүсвэр** | - | - |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | | |
| 145005 | Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 0.01 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 0.01 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **11,323,832,233.89** | **11,323,832,233.89** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **11,323,832,233.89** | **11,323,832,233.89** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **11,323,832,233.89** | **11,323,832,233.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 6,642,426,700.00 | 6,642,426,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 3,495,400,800.00 | 3,495,400,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,344,822,500.00 | 2,344,822,500.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 277,893,000.00 | 277,893,000.00 |
| 210104 | Урамшуулал | 524,310,400.00 | 524,310,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 942,182,000.00 | 942,182,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 694,188,200.00 | 694,188,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 61,998,400.00 | 61,998,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 49,598,800.00 | 49,598,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,399,700.00 | 12,399,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 123,996,900.00 | 123,996,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,739,223,533.89 | 3,739,223,533.89 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,739,223,533.89 | 3,739,223,533.89 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **11,323,832,233.90** | **11,323,832,233.90** |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **11,169,895,911.90** | **11,169,895,911.90** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 11,169,895,911.90 | 11,169,895,911.90 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 153,936,322.00 | 153,936,322.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 153,936,322.00 | 153,936,322.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 0.01 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | - | - |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | - | - |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | - | - |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **401.00** | **470.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 2.00 | 2.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 320.00 | 376.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 79.00 | 92.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | - | - |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **401.00** | **470.00** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 281.00 | 344.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 120.00 | 126.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх он** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **236,916,119.50** | **945,664,475.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **236,916,119.50** | **945,664,475.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 236,916,119.50 | 384,264,475.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 114,436,084.00 | 50,342,416.00 |
| 210101 | Үндсэн цалин | 70,126,572.00 | 35,042,416.00 |
| 210104 | Урамшуулал | 44,309,512.00 | 15,300,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 14,192,921.00 | 3,480,443.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,192,921.00 | 3,480,443.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,592,700.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 2,592,700.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | |
| **2105** | **Нормативт зардал** | 74,584,814.50 | 20,035,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 73,984,814.50 | 10,535,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 600,000.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 9,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 22,371,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,781,000.00 | |
| 210602 | Тавилга | 750,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 840,000.00 | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,408,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,408,000.00 | |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,480,600.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,480,600.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,850,000.00 | 310,406,616.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,850,000.00 | 310,406,616.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 561,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 561,400,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | - |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | - |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 236,916,120.50 | 945,664,475.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 236,916,120.50 | 945,664,475.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 400,000.00 | |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 25,635,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 213,995,750.00 | 877,877,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,520,370.50 | 42,152,475.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 29 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Нэгдсэн эмнэлэг нь хүн амд үзүүлэх эмнэлгийн ерөнхий болон төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг дэлхийн хөгжилтэй орны түвшинд  ойртуулж , орчин үеийн өндөр технологи нэвтрүүлсэн, чадварлаг багаас бүрдсэн оношилгоо, эмчилгээ, сувилгаа, сургалт судалгааны хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллага байх хэрэгжүүлэн ажилладаг байгууллага юм.

Тайлант онд тус эмнэлэг нь “Үйлчлүүлэгчдэд мэргэжлийн болон ёс зүйн өндөр ур чадвар, тэргүүний дэвшилтэд технологид тулгуурласан оношилгоо, эмчилгээ, сувилгааны цогц үйлчилгээг чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй үзүүлэхэд оршино” гэсэн зорилтын дор ажилласан байна.

Нэгдсэн эмнэлэг нь 2021 он 03 дугаар сарын 01-нээс Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлд суурилсан санхүүжилт авдаг болон өөрчлөлт орсон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус эмнэлгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Нэгдсэн эмнэлэгт дотоод аудитор ажилладаггүй, тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 1.2 сая төгрөгийн акт тогтоож барагдуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 10779.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 107.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 86.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6171.4 сая төгрөгөөр буюу 38.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 0.001 | 0.00 |
| Авлага | 85,996.40 | 2,256,199.10 | 2,170,202.70 |
| Бараа материал | 365,133.00 | 442,029.60 | 76,896.60 |
| Үндсэн хөрөнгө | 15,609,406.10 | 19,533,659.60 | 3,924,253.50 |
| **Нийт хөрөнгө** | **16,060,535.50** | **22,231,888.30** | **6,171,352.80** |
| Өр төлбөр | 485,209.80 | 648,242.40 | 163,032.60 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 15,575,325.70 | 21,583,645.90 | 6,008,320.20 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **16,060,535.50** | **22,231,888.30** | **6,171,352.80** |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансанд оны эцэст 0.0001 сая төгрөгийн харилцахын үлдэлдэлтэй.

Авлага дансны үлдэгдэл 2170.2 сая төгрөгөөр өссөн нь оны эхний 86.0 сая төгрөгийн авлагыг барагдуулж, оны эцэст Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 2256.2 сая төгрөгийн авлагатай гарсан байна. Дээрх санхүүжилтийн авлага нь 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр барагдсан байна

Бараа материалын дансны үлдэгдэл 442.0 сая төгрөг болж 76.9 төгрөгөөр өссөн байна. Бичиг хэрэг 5.0 сая, аж ахуйн материал 27.8 сая, барилгын засварын материал 6.3 сая, бусад хангамжийн материал 44.7 сая төгрөгөөр нэмэгджээ. Энэ нь тайлант онд шинээр Хүүхдийн 50 ортой эмнэлгийн барилга ашиглалтад орсноор үйл ажиллагаатай холбоотой зардлууд нэмэгдсэн, мөн Ковид-19 цар тахалтай холбоотой худалдан авалтууд нэмэгдсэн холбоотой байна.

Тайлант онд 2611.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 785.2 сая төгрөгийн үнэ төлбөргүй материалыг хүлээн авч, 3305.2 сая төгрөгийн материалыг зарцуулж, 5.0 сая төгрөгийн эмийн үнийн буцаалт хийж, 11.9 сая төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 19533.6 сая төгрөг болж 3924.3 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 48.1 сая, хөрөнгө оруулалтаар 435.7 сая төгрөгийн 2 тасгийн их засвар, амбулаторын коридорын засвар, Эрүүл мэндийн яамнаас 135.0 сая төгрөгийн автомашин, мөн Эрүүл мэндийн яамнаас 3176.0 сая, Link Hands for Humanity ОУБ-аас 153.6 сая, Глобаль сангаас 239.0 сая, аймгийн ОНХС-гаас 41.2 сая, аймгийн ЭМГ-аас 9.2 сая, Улаанхус сумын Эрүүл мэндийн төвөөс тогтоолоор 37.6 сая, нийт 3656.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 585.5 сая төгрөгийн хүчил төрөгчийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, 85.6 сая төгрөгийн хүүхдийн тасгийн камержуулалт, тавилга бүгд 671.1 сая төгрөгийн тавилга эд хогшил, 56.3 сая төгрөгийн программ хангамж, 30.1 сая төгрөгийн шилжүүлэн авсан автомашин нийтдээ 4954.8 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж,

зохих шийдвэрийн дагуу 4.1 сая төгрөгийн барилга, 74.0 сая төгрөгийн автомашин, 769.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 12.8 сая төгрөгийн тавилга эд хогшил бүгд 860.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 72 дугаар тогтоолоор аймгийн Цагдаагийн газарт 30.1 сая төгрөгийн автомашин, ИТХ-ын Тэргүүлэгчдийн 28 дугаар тогтоолоор 20.4 сая төгрөгийн газар эзэмших эрхийг балансаас балансад шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийн өсөлт нь шинээр ашиглалтад орсон барилга, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийн дүнгээр нэмэгдэж ихээхэн хэмжээний өөрчлөлт орсон байна.

Тайлант онд нийт акталсан хөрөнгөөс 769.4 сая төгрөгийн 85 нэр төрлийн тоног төхөөрөмж, 12.7 сая төгрөгийн 27 нэр төрлийн тавилга эд хогшлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 58, 133 дугаар тогтоол, эмнэлгийн Өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтэд үндэслэн, даргын тушаалаар устгалын комисс томилж, устгалтыг хийж баримтжуулсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 648.2 сая төгрөг болж 163.0 төгрөгөөр нэмэгдсэн. Энэ нь ажиллагсадтай холбоотой өглөг 5.5 сая төгрөгөөр, түлш халаалтын өглөг 83.4 сая төгрөгөөр буурсан боловч, оны эцэст Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг бүрэн авч чадаагүйгээс өглөг нэмэгдсэн байна.

Үүнээс цалин хөлстэй холбоотой 8.8 сая төгрөгийн, түлш халаалтын 52.9 сая төгрөгийн, эмийн 530.7 сая төгрөгийн, бусад зардлын 56.0 сая төгрөгийн, бүгд 648.2 сая төгрөгийн өглөгтэй гарсныг Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлагыг барагдуулж 2022 оны 1 дүгээр сарын байдлаар 571.0 сая төгрөгийн өглөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өөрчлөлтгүй байна.

Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 20295.8 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 5024.3 сая төгрөгөөр буюу 32.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, даатгалын санхүүжилт, нэмэлт санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого байна. Тайлант оны санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан материалуудын өөрчлөлт нь Ковид-19-той холбоотой өөрчлөлт нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 3442.4 сая төгрөгөөр буюу 31.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ, нормативт зардал, бараа үйлчилгээний зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар акталсан хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой 4.2 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулах бичилт гарсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус эмнэлгийн 2021 оны анх батлагдсан төсөв 10163.6 сая төгрөг ба 2021 оны 03 дугаар сарын 01-нээс Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжилт авдаг болсонтой холбоотойгоор батлагдсан төсөв 11323.8 сая төгрөг болж анх баталсан төсөв 1160.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөв баталж эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 11169.9 сая төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 153.9 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 11169.9 сая төгрөгийн, өөрийн орлогоос 153.9 сая төгрөгийн, нийтдээ 11323.8 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 11323.8 сая төгрөг зарцуулж төсвийн гүйцэтгэл 100.0 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр арга хэмжээ, батлагдсан төсөв гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| № | Хөтөлбөр | Арга хэмжээ | Нэршил | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 71602 | 71602 | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | | | | |
| 2 | | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 11,323,832.2 | 11,323,832.2 | 0.0 | 100 |
| **Нийт дүн** | | | | **11,323,832.2** | **11,323,832.2** | **0.0** | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус эмнэлэгт тайлант онд 156.9 төгрөгийн орлогын төлөвлөгөө өгөгдснөөс гүйцэтгэлээр 156.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт 3.* Өөрийн орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 153,936.3 | 153,936.3 | 0.0 | 100 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | | | |
| **Нийт дүн** | **153,936.3** | **153,936.3** | **0.0** | **100** |

Үндсэн үйл ажиллагааны орлогыг тусламж үйлчилгээ, томограф, ор хоног, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний төлбөрүүдээс бүрдүүлсэн байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 1 хөтөлбөр, 1 төсөл арга хэмжээний зардалд нийгмийн халамжийн сангаас 16.0 сая, цахим тендерийн орлогоос 3.1 сая төгрөгийн, нийтдээ 19.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж зарцуулсан байна

Тайлант онд Эрүүл мэндийн яамнаас 1 төсөл арга хэмжээний зардалд 877.8 сая төгрөгийн, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 25.6 сая төгрөгийн, PCR шинжилгээний орлогоос 42.1 сая төгрөгийн, нийтдээ 945.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт бүрдүүлж, гүйцэтгэлээр 945.6 сая төгрөгийг бүрэн зарцуулсан байна.

Зарцуулалтыг авч үзэхэд: 53.8 сая төгрөгийг цар тахал, урьдчилан сэргийлэх үзлэгийн урамшуулал цалин, НДШ-д, 20.0 сая төгрөгийг эм, нормын хувцас зөөлөн эдлэлд, 310.4 сая төгрөгийг бараа үйлчилгээний, 561.4 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлуудад тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас ажилчдын урамшуулал цалинд бараа үйлчилгээний зардлаас 8.9 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Нэгдсэн эмнэлгийн бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Тус эмнэлэг нь Эрүүл мэндийн даатгалын сангаас Нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж гүйцэтгэлд суурилсан санхүүжилт авч үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой 2021 онд Төлөөлөн удирдах зөвлөл байгуулагдаагүй тул төсөв санхүү гүйцэтгэлээр гарсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2021 онд нийт 26,632.3 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 104 мэдээллийг хугацаандаа байршуулж, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээлэл буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шилэн дансанд тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс 521.1 сая төгрөгийн 124 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах, Шилэн дансанд заавал байршуулах мэдээллийг бүрэн байршуулах талаар зөвлөмж өгөгдсөн ба өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй боловч санхүүгийн тайлангийн аудитыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул гүйцэтгэлийн шалгалтаар төсвийн зарцуулалтыг бүрэн үзэх шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | |